



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 10

Эрдэнэт


**“Өрхийн тариалалтыг дэмжих”  
хөтөлбөр батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “е”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 7.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Өрхийн тариалалтыг дэмжих” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 10 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ